БУЛГАН АЙМАГ

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... дугаар сарын ..-ний өдөр Булган сум

Дугаар....

ЖУРАМ, ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “д” дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.4 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар “Аргачлал батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралт “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал”-ын 1 дүгээр зүйлийн 1.1.дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн IV Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах зорилго бүхий “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах булшлах журам”-ыг 1 дүгээр, нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба /Д.Батчулуун/-д үүрэг болгосугай.
3. Дээрх тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс аймгийн хэмжээнд мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Ариун-Эрдэнэ/, сумын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА Д.ЭРДЭНЭБАТ

9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

9.1.Хог хаягдлын талаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.3.энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх;

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын . . .
Хуралдааны 2021 оны ... дугаар сарын . . . .-ний өдрийн
. . . дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.

1.1.Энэ журмаар аймгийн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах, ангилан ялгах ангиллын дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, нийтийн эдэлбэр газрыг цэвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг эрхлэхэд үүсэх харилцааг зохицуулна.
1.2. Энэ журам нь Хог хаягдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
1.3.Энэхүү журмыг аймгийн нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч байгаа иргэд, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд дагаж мөрдөнө.
1.4.Журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагч болон хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан, гэрээгээр эрх олгосон төрийн бус байгууллага, олон нийтийн хяналтыг иргэдийн бүлэг, иргэн тавина.

ХОЁР. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ.

2.1. Аймгийн ИТХ-ын үүрэг

2.1.1.Журмын хэрэгжилтэд хяналт тавих.

2.2. Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг:

2.2.1.Журмын хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцаж, тайлагнах;
2.2.2.Энгийн хог хаягдал булшлах, устгах үйл ажиллагаа эрхлэх байгууллагатай гэрээ байгуулах, зөвшөөрөл олгох;
2.2.3.Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон үед хуваарьт бус бүх нийтийн их цэвэрлэгээг зарлах;
2.2.4.Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, булшлахад шаардагдах төсөв, техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.3. Булган сумын Засаг даргын үүрэг

2.3.1.Булган сумын Засаг дарга энэ журмын 2.4 дүгээр зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүргийг хэрэгжүүлнэ.
2.3.2.Сумын нутаг дэвсгэр дэх энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих, бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах;
2.3.3.Сумын хилийн цэс харгалзахгүйгээр нэгдсэн удирдлага зохион байгуулалттайгаар цэвэрлэгээ хийх нийтийн эдэлбэр газарт хамаарах гудамж, зам талбай, хотоос алслагдсан зам, замын байгууламжийн жагсаалтыг батлах;

2.3.4.Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах,тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болох ба хяналтын төрийн бус байгууллагыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж ажиллуулах;
2.3.5.Сумын хэмжээнд хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааны нэгдсэн арга зүйг боловсруулах;

2.4. Сумын Засаг даргын хүлээх үүрэг:

2.4.1.Журмын 2.3.2-д зааснаас бусад сумын хилийн цэс доторх нийтийн эдэлбэр газарт хамаарах гудамж, зам талбайн жагсаалтыг батлах;
2.4.2.Бүх нийтийн их цэвэрлэгээнд хамрагдах сумын нутаг дэвсгэрийн гудамж, зам, талбай, ногоон бүсийн зураглалыг гаргаж төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, ерөнхий боловсролын сургуульд зураглалаар хариуцуулан, хуваарь гарган батлах;
2.4.3.Сумын нутаг дэвсгэр дэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааг журмын 2.3.4-д заасан арга зүйн дагуу улиралд хоёроос доошгүй удаа тогтмол зохион байгуулах;
2.4.4.Сумын нийтийн эдэлбэр газар, гудамж талбайд хоёроос доошгүй төрлөөр ангилан ялгах хогийн савыг байршуулах ба шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгуулах;
2.4.5.Сумын нутаг дэвсгэрт журмын хэрэгжилтийг хангах, нийтийн эдэлбэр газарт ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх арга хэмжээг авч ажиллах;
2.4.6.Сумын нийт айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын ачилт, цуглуулалт, тээвэрлэлтийн үйлчилгээг өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2-т заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, шалгарсан байгууллагатай “Сумын нутаг дэвсгэрт хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх гэрээ” байгуулан гүйцэтгүүлэх;
2.4.7.Сумын нутаг дэвсгэр хог ачиж, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх хог хаягдлын үйлчилгээний байгууллагыг сар бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 41.10 дахь хэсэгт заасны дагуу санхүүжүүлэх;
2.4.8.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-д заасан хэмжээгээр тооцож авахад хяналт тавих, үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх;
2.4.9.Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.7, 9.4.14-д заасны дагуу хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулж, шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж батлуулах;
2.4.10.Сумын газар нутгийн онцлогоос хамаарч ангилсан хог хаягдлыг худалдан авах, түр хадгалах цэгийн байршлыг тогтоох;
2.4.11.Зам талбайн цэвэрлэгээг аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас баталсан тарифыг үндэслэн цэвэрлэгээний зардлыг сумын төсөвт тусгаж, Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулах;
2.4.12.Хог хаягдлыг багасгах, ангилан ялгах талаар шинэ санал, санаачлага гаргасан аж ахуй нэгж, байгууллага, айл өрх, иргэнийг энэ журмын 5.1 дэх хэсэгт заасны дагуу урамшуулах;

2.5.Багийн Засаг даргын хүлээх үүрэг:

2.5.1.Багийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг сумаас зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгаанд хамруулах;
2.5.2.Хог ачиж, цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавих;
2.5.3.Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;
2.5.4.Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг ангилуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, бүртгэл хөтлөх;
2.5.5.Орон сууц, гэр хорооллын оршин суугч иргэдийн бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцсон талаар бүртгэл хөтөлж, тэмдэглэгээ хийх;

2.5.6.Багийн оршин суугчид болон байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

2.6.Аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийн хүлээх үүрэг:

2.6.1.Аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо нь Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.10-т заасны дагуу орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг тогтмол цэвэрлэх;
2.6.2.Журмын 2.6.1-д заасан үүргийг гүйцэтгэхгүй тохиолдолд сумын Засаг дарга мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гарсан зардлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо хариуцах;
2.6.3.Аж ахуйн нэгж, байгууллага нь бүх нийтийн их цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж хэрэгслээр хангах;
2.6.4.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь журмын 2.4.4-т заасан сум, багаас зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах;
2.6.5.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь нь хог хаягдлаа журмын 3.1.2-т заасны дагуу эх үүсвэр дээр ангилан ялгах;
2.6.6.Аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо нь гадна талбайдаа хог хаягдал хадгалах сав, бункертэй байх ба доорх шаардлагыг хангасан байх;

2.6.6.1.Хогийн сав нь Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагаас гадна шавьж, мэрэгч, шувуу, амьтан орох боломжгүй хамгаалалт, хаалт, тагтай байна;
2.6.6.2.Журмын 3.1.3-д заасан ангиллын төрлийг заасан таних тэмдэг, өнгөтэй байна;
2.6.6.3.Хог хаягдлыг ангилж хийх, хадгалахад хялбар хийц загвартай, өнгө үзэмжтэй байна;
2.6.6.4.Хогийн савыг тогтмол цэвэрлэн, сард нэгээс доошгүй удаа ариутгана;

2.6.7.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ангилсан хаягдлыг зориулалтын уутанд хийж, уутны амыг боож битүүмжлэн энэхүү журмын 2.6.6-д заасан хогийн сав, бункерт байршуулан, хадгалах ба хог ачиж цуглуулах хуваарийн дагуу хог тээврийн авто машинд ачуулах;
2.6.8.Барилга, байгууламжийг өргөтгөх, шинээр барихдаа түүний зориулалт, хүн амын нягтрал, хог хаягдлын үүсэх хэмжээ, ангиллын төрлөөс хамаарч хог хаягдал хадгалах байр, талбайн байршлыг барилга, байгууламжийн зураг, төсөлд тусгасан байх;
2.6.9.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 0.75 м.кубээс дээш эзлэхүүнтэй овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-д заасны дагуу нэмэлт үйлчилгээний хөлс төлж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх;
2.6.10.Аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, айл өрхүүд хог хаягдлаа эрх бүхий мэргэжлийн байгууллагатай “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ” байгуулж ачуулах ба уг гэрээнд хог ачих өдөр, цаг, давтамжийг тодорхой заах;
2.6.11.Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд сумаас зураглалаар хариуцуулсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбайн хог хаягдлыг цэвэрлэж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгөх;
2.6.12.Аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нийт борлуулсан согтууруулах ундааны шилэн лонхныхоо 30-аас доошгүй хувийг эргүүлэн татаж, дахин ашиглах;
2.6.13.Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь үүсгэж буй энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь заавал ангилна.

2.7.Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг:

2.7.1.Сумын Засаг даргын баталсан өдөр, хуваарийн дагуу дахин ашиглах болон бусад хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг эрхлэх. Үйл ажиллагаандаа холбогдох чиглэлээр гарсан хууль дүрэм, журам, Монгол Улсын стандартыг мөрдөж ажиллах.

2.7.2.Иргэдийн эрүүл мэнд, амгалан тайван байдлыг алдагдуулахгүйгээр, хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байх, замын хөдөлгөөний дүрмийг сахин хөдөлгөөнд оролцож хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээг үзүүлэх.
2.7.3.Тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ бусад мэдээллийг улирал бүр сумын Засаг дарга Тамгын газарт гаргаж өгнө.

ГУРАВ.ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ БУЛШЛАХ

3.1.Энгийн хог хаягдлыг ангилах

3.1.1.Хог хаягдлыг ангилах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.7-д “Хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгах/ заасныг хэлнэ.
3.1.2.Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр дараах байдлаар ангилна.
3.1.2.1.Дахин боловсруулах боломжтой хог хаягдал
3.1.2.2.Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал
3.1.3.Хог хаягдлыг дараах төрлийн өнгөөр илэрхийлнэ.
- Хуванцар, гялгар уут – Ногоон;
- Хөнгөн цагаан лааз, металл хаягдал – Улбар шар;
- Цаас – Цэнхэр;
- Шил – Цагаан;
- Хүнсний органик хаягдал – Бор;
- Бусад хог хаягдал – Хар;
- Ахуйн аюултай хог хаягдал – Шар.

3.1.4.Журмын 3.1.2 дахь заалтад заасан энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төрлийг хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлтэй уялдуулан аж ахуйн нэгж, байгууллага, иргэд өөрсдийн санаачлагаар нэмэгдүүлж болно.
3.1.5.Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг худалдан авах,түр хадгалах цэг нь орчны аюулгүй байдлыг хангасан, хог хаягдлыг төрөлжүүлэн, эмх цэгцтэй хадгалж, хог хаягдлыг нягтруулах төхөөрөмжтэй байна.
3.1.6.Дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг худалдан авах,түр хадгалах цэг нь үйл ажиллагаандаа холбогдох стандартыг мөрдөж ажиллана.

3.2.Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх:

3.2.1.Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх ажлыг сумын Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулсан этгээд хийж гүйцэтгэнэ.
3.2.2.Сумын Засаг дарга нар хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулна.
3.2.3.Гэрээ байгуулсан эрх бүхий иргэн, байгууллага хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг холбогдох стандартад нийцүүлэн явуулна.
3.2.4.Хог тээвэрлэх автомашин нь стандарт шаардлага хангаж, тээврийн хэрэгслийн үзлэг, оношлогоонд хамрагдсан, байгаль орчин, агаарын чанарт сөрөг нөлөөгүй байна.
3.2.5. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж байгууллага дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
3.2.5.1.Энгийн хог хаягдал цуглуулалт тээвэрлэлтийн хуваарь, статистик тоо, мэдээ, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого, түүний зарцуулалт, маршрут, хүний нөөц, машин техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл, хог хаягдлын талаарх хууль, эрх зүйн мэдээлэл, иргэдэд чиглэсэн хог хаягдлын боловсрол олгох сурталчилгааны мэдээлэл бүхий байгууллагын цахим хуудсыг ажиллуулах
3.2.5.2.Энгийн хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээнд гарч буй жолооч, ачигчдыг хог хаягдлын талаарх хууль тогтоомж, харилцааны соёл, хог ачиж, цуглуулах, тээвэрлэх арга зүй, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны талаар сургалтад жилд 1-ээс доошгүй удаа хамруулах

3.2.5.3.Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд ажиллаж байгаа жолооч, ачигчийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан өвөл, зуны ажлын хувцсаар жилд нэг удаа хангах;
3.2.5.4.Цуглуулж, тээвэрлэсэн энгийн хог хаягдлын төрөл, эх үүсвэр, тоо хэмжээний талаарх тайлан мэдээг сумын Засаг даргын тамгын газарт, хагас бүтэн жилээр гаргаж өгөх
3.2.5.5.Энгийн хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний орлогын хоёроос доошгүй хувийг иргэдийн хог хаягдлын боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагаанд зарцуулах
3.2.5.6.Айл өрхийн хог хаягдлыг баталсан графикийн дагуу тогтмол хугацаанд ачиж тээвэрлэх.
3.2.5.7.Энгийн хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх бүх авто машиныг даатгал, үзлэг оношлогоонд бүрэн хамруулж, авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэг хөтлөх
3.2.5.8.Хог тээврийн авто машины бүрэн, бүтэн байдлыг ажилд гарахаас өмнө шалгаж, ажилд гарах зөвшөөрөл өгөх бөгөөд бүрэн бус тээврийн хэрэгслийг үйлчилгээнд гаргахгүй байх;
3.2.5.9.Энгийн хог хаягдлыг авто машины даац, тэвшний өндөрт тохируулан ачиж, битүүмжлэн тээвэрлэх ба тээвэрлэлтийн явцад хог хаягдал хийсэх, тархах, асгарахаас сэргийлэх арга хэмжээ авах
3.2.5.10.Энгийн хог хаягдлыг ачиж, тээвэрлэсний дараа тээврийн хэрэгсэл болон тэвшийг тогтмол цэвэрлэж, сард хоёроос доошгүй удаа ариутгал, халдваргүйжүүлэлт хийх
3.2.5.11.Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад хог ачиж тээвэрлэх хуваарийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэх;

3.2.6.Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын газрын эрх бүхий байцаагч, тухайн сумын Засаг даргын Тамгын газар, багийн Засаг дарга хяналт тавина.
3.2.7. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэхдээ хүрээлэн буй орчин, хөрсийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авна

3.3.Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах

3.3.1.Энгийн хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2 дахь заалтад заасан зөвшөөрөл авсан, 8.1.9.б-д заасны дагуу бүртгүүлсэн хуулийн этгээд гүйцэтгэнэ.
3.3.2.Энгийн хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 8.1.3-д заасан журмын дагуу дахин боловсруулсан болон сэргээн ашигласан хог хаягдлын мэдээ, тайланг хагас, бүтэн жилээр сумын Засаг даргын Тамгын газарт гаргаж өгнө.
3.3.3.Энгийн хог хаягдал дахин ашиглах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.
3.3.4.Энгийн хог хаягдал дахин ашиглах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтад заасан ерөнхий шаардлагыг удирдлага болгоно.
3.3.5.Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч сэргээн ашиглах хог хаягдлаа төрөлжүүлэн цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сумын Засаг даргатай гэрээ байгуулан гүйцэтгэж болно.
3.3.6.Хог хаягдал дахин боловсруулах, сэргээн ашиглах төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгжид Газрын тухай хууль, бусад хууль тогтоомжид заасны дагуу газар олголт болон дэд бүтцээр дэмжлэг үзүүлнэ.
3.3.7.Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын газар, тухайн сумын Засаг даргын Тамгын газар, багийн Засаг дарга хяналт тавина.
3.3.8. Мэргэжлийн хяналтын байгууллагаас тухайн хоёрдогч түүхий эд дахин боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд үйл ажиллагааг нь холбогдох хууль, журмын дагуу зогсооно

3.4.Энгийн хог хаягдлыг устгах, булшлах

3.4.1.Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийг дараах байдлаар төлөвлөнө.

3.4.1.1.Хог хаягдлын төвлөрсөн цэгийг төлөвлөхдөө хог хаягдлын суурь судалгааг үндэслэн хог хаягдлын бүтэц, нягт, үүсэх хэмжээг харгалзан булшлах технологийг сонгох;

3.4.1.2.Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршлыг сонгох, төлөвлөхөд тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангаж ажиллах;

3.4.2.Хог хаягдлын төвлөрсөн цэгийг төлөвлөх, зураг, төслийг хийхэд доорх хүчин зүйлсийг харгалзана.

3.4.2.1.Тухайн сонгосон нутаг дэвсгэрт арваас дээш жил хог хаягдал хүлээн авах нөөцтэй эсэх;

3.4.2.2.Хөрсөөр хучих шороо, хөрс олборлох боломжтой;

3.4.2.3.Хууль тогтоомжоор хориглосон байршил болон хог хаягдлын төвлөрсөн цэгийн хил, хязгаарын зааг шаардлагад нийцсэн;

3.4.2.4.Салхины зонхилох чиглэл;

3.4.2.5.Дэд бүтэц, авто замын сүлжээ, харилцаа холбоо;

3.4.2.6.Бусад эрсдэл.

3.4.3.Хог хаягдлын төвлөрсөн цэгийн ландфилын талбайг төлөвлөхдөө дараах шаардлагыг харгалзана. Үүнд:

3.4.3.1.Шимт хөрсийг нөөцлөн хог хаягдлын төвлөрсөн цэгийн ногоон байгууламж болон нөхөн сэргээлтэд ашиглах;

3.4.3.2.Мод, бут сөөгийг шилжүүлэн суулгах;

3.4.3.3.Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үүрийг ухаж бэлтгэх, гарсан шороог үерийн хамгаалалтын далан эсвэл хучилтад нөөцлөх;

3.4.3.4.Суурийг бэлтгэхдээ 2 градусаас доошгүй налуутай шүүрлийн ус цуглуулах боломжтойгоор бэлтгэх;

3.4.3.5.Хог хаягдлын бүтэц, жилийн дундаж хур тунадасны хэмжээ, хогийн цэгт устгаж, булшлах хог хаягдлын хэмжээ, хими, физикийн шинж чанараас шалтгаалан суурийн хучилтын технологийг сонгох;

3.4.3.6.Ландфилын талбайд мембран дэвсгэр шаардлагагүй тохиолдолд ус нэвчих хурд $1x10^{-6}$ см\сек доошгүй байхаар шавар хөрсийг нягтруулан суурийг бэлтгэх ба мембран давхарга шаардлагатай тохиолдолд 2 мм-ээс багагүй зузаантай (+40 өөс -40 хэм) тэсвэрлэх чадалтай, уян HDPE материал сонгох.

3.4.4.Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хог хаягдал булшлах хог хаягдлын төвлөрсөн цэгийг барьж байгуулах тохиолдолд аймаг, сумын Засаг даргаас зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллана.

3.4.5.Энгийн хог хаягдал устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4.5.1.Энгийн хог хаягдал устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг ажилтнуудыг ажилд гарахын өмнө өдөр бүр өгөх ба хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийн бүрэн, бүтэн байдлыг шалгаж ажилд гаргах;

3.4.5.2.Ажилтан, албан хаагчдыг өвөл болон зуны улирлын хөдөлмөр хамгаллын багаж хэрэгсэл, ажлын хувцас, гутлаар хангах;

3.4.5.3.Ажилтан, албан хаагчдыг хог хаягдлын хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, шаардлага болон хог хаягдлыг устгах, булшлахтай холбоотой мэргэжлийн сургалтад хамруулан мэргэшүүлж ажиллуулах;

3.4.5.4.Хог хаягдлын төвлөрсөн цэгийн үүр болон хог хаягдал хүлээн авч буй талбайд ил гал гаргах, тамхи татах болон шатах, тослох материал агуулахгүй байх;

3.4.5.5.Хог хаягдлын төвлөрсөн цэгт мал, амьтан оруулах, бэлчээх, тэжээхгүй байх;

3.4.5.6.Хог хаягдлын төвлөрсөн цэгт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалд хамруулах;

3.4.5.7.Хог хаягдлын төвлөрсөн цэгт хүлээн авч устгаж булшилсан хог хаягдлын дэлгэрэнгүй бүртгэл бүхий мэдээллийн сантай байх бөгөөд энэхүү мэдээллийн санг аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхэлдэг эрх бүхий байгууллагад тухай бүр ашиглуулах;

3.4.5.8.Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдал хүлээн авах ландфилын талбай, аюул, осол, байгалийн гамшгийн үед хог хаягдал хүлээн авах нөөц талбай, хог дарж булшлах

хөрс бэлтгэж нөөцлөх талбайг тус тус төлөвлөх ба энэхүү төлөвлөлтийг жил бүр гаргаж, байгууллагын даргаар батлуулах;

3.4.5.9.Дахин боловсруулах хог хаягдал түүгч иргэдийг хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайд нэвтрүүлэхгүй, хог түүх үйл ажиллагааг эрхлүүлэхгүй байх;

3.4.5.10.Хог хаягдлын төвлөрсөн цэгт хог хаягдал тээвэрлэж ирсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тухайн хог хаягдлыг ландфилд дарж булах зардлыг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад заасан энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифаар тооцож авах;

3.4.6.Энгийн хог хаягдал устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах шаардлага

3.4.6.1.Хог хаягдлын төвлөрсөн цэгт ажиллах машин, техникүүд нь олон улсын болон үндэсний стандарт шаардлагыг хангасан байх;

3.4.6.2.Хог хаягдал тээвэрлэн ирж байгаа авто машиныг ачаатай үед хог хаягдлын төвлөрсөн цэгт орохоос өмнө ачиж, тээвэрлэсэн хог хаягдлын эх үүсвэр, хог хаягдлын төрлийг тодорхойлж, бүртгэл хөтлөн биологийн, химийн болон аюултай, шатах, дэлбэрэх эрсдэлтэй хог хаягдал илэрвэл хог хаягдлын төвлөрсөн цэгт нэвтрүүлэхгүй байх;

3.4.6.3. Хог хаягдлын төвлөсөн цэгийн бүртгэлийн байртай байна.

3.4.7.Хог хаягдлын төвлөрсөн цэгт шингэн хог хаягдал, хүний шарил, эд эрхтэн, тэсэрч дэлбэрэх, химийн, аюултай хог хаягдал булшлахгүй байх.

3.4.8.Хог хаягдлыг төвлөрсөн цэгт дарж, булшлах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.11-д заасны дагуу булшилсан хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.

ДӨРӨВ. ХОРИГЛОХ ЗҮЙЛ, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

4.1.Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгалгүй хаях, шатаахыг хориглоно.

4.2.Ангилан ялгасан хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх эрх бүхий иргэн, байгууллагаас өөр этгээд цуглуулах, тээвэрлэхийг хориглоно.

4.3.Хог хаягдлыг зориулалтын бус газар, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, далан, шуудуунд ил задгай хаяхыг хориглоно.

4.4.Хог хаягдлын тухай хууль зөрчигчдөд Зөрчлийн тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ТАВ. УРАМШУУЛАЛ

5.1.Хог хаягдлын анхан шатанд ангилан ялгаж хэвшсэн, хог хаягдлыг дахин ашиглах шинэ санал санаачлага гаргасан, мөн хоёрдогч түүхий эдийг цуглуулах, тээвэрлэх дахин боловсруулахад бусдад үлгэр дуурайлал болсон айл өрх, иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулж, олон нийтэд сурталчлан бүх талаар дэмжиж ажиллана.

5.2.Энэ журмын 5.1-д заасан дэмжлэг, урамшууллын арга хэмжээг тухайн иргэн аж ахуйн нэгжийн хүсэлт, багийн Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн сумын Засаг дарга зохион байгуулна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын IV
Хуралдааны 2021 оны ... дугаар сарын . . . .-ний өдрийн
. . . дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

НИЙТИЙН ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Ажлын нэр	Хэмжих нэгж /га/	Үнийн тариф /төг/
1	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх тариф	1	9400-11400

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШЛАХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ

№	Сумдын нэр	Хэмжих нэгж /тн/	Үнийн тариф /төг/
1	Булган сум	1	12000-15000
2	Бусад сумд	1	10000-12000

Тайлбар: Цэвэрлэх, булшлах ажилд ашиглах машин техникийн марк, тухайн үеийн зах зээлийн шатахууны үнэ ханшнаас хамаараад тариф хэлбэлзэж болно.